



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-10

1.Батлан хамгаалах яамны 2025 оны үйл ажиллагааны
тайлан

4-10

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
4 дүгээр сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Н.Батсүмбэрэл, Х.Жангабыл, Ж.Энхбаяр;
Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Р.Эрдэнэбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар;
Тасалсан: Э.Бат-Амгалан, Б.Жаргалан.

Нэг.Батлан хамгаалах яамны 2025 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч Ж.Болдбаатар, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга М.Батхуяг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Мөнхбаяр, Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газрын дарга Р.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх М.Отгон, С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа нар байлцав.

Батлан хамгаалах яамны 2025 оны үйл ажиллагааны тайланг Батлан хамгаалахын сайд Д.Батлут танилцуулав.

Батлан хамгаалахын сайд Д.Батлут маш нууцын зэрэгтэй тоо, баримтууд дурдагдах учраас тайланг хаалттай хуралдаанаар хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Батлан хамгаалахын сайд Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 20 минут үргэлжилж, 29 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 13 цаг 20 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Батын Батбаатар гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн байнгын хорооны ирц бүрдсэн байна аа.

Ингээд 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дээр нэг хэлэлцэх асуудал байгаа.

Батлан хамгаалах яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Батлан хамгаалах сайдын мэдээллийг сонсохоор байгаа. Өнгөрсөн 7 хоногт бид бүхэн ГХЯ-ны тайлан мэдээллийг сонссон. 2019 он хүртэлх Улсын Их Хурлын тухай хууль болоод Дэгийн тухай хуулиар шууд ажлаа тайлагнадаг байгууллагын тайлан мэдээллийг бол албан ёсоор жил бүр сонсдог байсан. Ингээд хэдий одоо Дэгийн тухай хуульд 2019 онд өөрчлөлт ороод мэдээллээ сонсохоо больсон ч одоо бас жил бүр бол ингээд бид нар тайлан мэдээллүүдийг ингээд сонсож байгаа. Холбогдох шууд ажлаа тайлагнадаг ГХЯ болон Батлан хамгаалах яамны мэдээллүүдийг бол бас ингээд энэ хавар сонсож байна.

Мөн дээрээс нь очиж ажиллах байгууллагууд бол байгаа гэдэг зүйлийг хэлэх байна. Хоёр 7 хоногийн дараа мөн Батлан хамгаалах яамны харьяа Жанжин штаб дээр ажиллах төлөвлөгөөтэй байгаа гэдгээ та бүхэнд мэдээлэл хүргэе ээ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Батлан хамгаалах яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Батлан хамгаалахын сайдын мэдээллүүдийг сонсоцгооё. Ажлын хэсгийг оруулаарай. Батлан хамгаалахын сайд Батлут сайд хүрэлцэн ирсэн байна.

Мэдээллийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут сайд хийнэ ээ. Батлут сайдыг микрофонд урьж байна.

Д.Батлут: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Манай батлан хамгаалах салбарын энэхүү гүйцэтгэлийн тайлан бас нууцын

зэрэглэлтэй учраас нууцын зэрэглэлтэй байгаа. Тэгэхээр хаалттай хийх горимоор хийхийг хүсэж байна. Хаалттай горим.

Г.Тэмүүлэн: Батлут сайдыг микрофонд урьж байна.

Д.Батлут: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье ээ.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Алсын хараа 2050 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн Үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилго зорилттой уялдуулан Батлан хамгаалах яамнаас 2025 оныг батлан хамгаалах тогтолцоонд сэргэлт хийж, эх оронч үзэлд суурилсан хүн төвтэй бодлого хэрэгжүүлж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ гэсэн зорилго дэвшүүлж 17 зорилт, 118 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2025 онд Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Ерөнхийлөгч ҮАБЗ-ийн түвшинд 5, Улсын Их Хурлын түвшинд 3, Засгийн газрын түвшинд 30 гаруй ажил арга хэмжээг хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргууллаа. Тухайлбал Монгол Улсын Ерөнхийлөгч ҮАБЗ-ийн түвшинд батлан хамгаалах салбарын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа болон шийдвэрлэх асуудал, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны цэргийн хүчний бүрэлдэхүүнийг бууруулах шийдвэрийн тухай, Монгол Улсын үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги баримт бичгийн төсөл болон батлан хамгаалах зэвсэгт хүчний нийт бие албан хаагчдын эрүүл мэндийн байдлын талаар танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулсан.

Улсын Их Хурлын түвшинд Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд 211.2 тэрбум төгрөгийн 15 төсөл арга хэмжээ, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 1.6 их наяд төгрөгийн 7 төсөл арга хэмжээг тусгуулсан болно оо. Мөн Батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлуулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулсан. Засгийн газрын түвшинд Засгийн газрын 2025 оны 161 дүгээр тогтоолоор Зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын албан хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох журмыг шинэчлэн тогтоолоо. Үүний үр дүнд албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулахад бодитой дэмжлэг болж, өөрийгөө хөгжүүлэх болон цэргийн сургалт бэлтгэлийн чанар сайжруулахад бодитой нөлөө үзүүлсэн болно оо.

Засгийн газрын 2025 оны 70 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Сант суманд барилга, инженер, экологийн цэргийн ангийг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Тус ангийн анги байгуулагдсанаас цэргийн албан хаагчид МАА, газар тариалан эрхлэх, ойжуулах, цэцэрлэгжүүлэх, ойн баялгийг зүй зохистой ашиглах мэдлэг дадлага эзэмших, ажилтай орлоготой монгол хүн хэмээх төрийн бодлогын хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлэх ач холбогдолтой юмаа.

Засгийн газрын 2025 оны томилолтын зардлыг шинэчлэх тухай 133 дугаар тогтоолоор энхийг дэмжих ажиллагааны үүрэг гүйцэтгэсэн албан хаагчдын томилолтын зардлыг 14 жилийн дараа 10 хувиар нэмэгдүүлж, энхийг сахиулагчид

томилолтын зардлын 80 хувийг олгохоор шийдвэрлэсэн нь албан хаагчдад санхүүгийн бодит дэмжлэг болох нөхцөлийг бүрдүүлсэн болно оо.

Засгийн газрын хуралдаанд хугацаат цэргийн албан хаагчдад тухайн орон нутагт шаардлагатай мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай асуудлыг танилцуулж, Засгийн газрын 22 дугаар тэмдэглэлээр албажуулсан болно. Ингэснээр цэргийн насны залуучуудад алба хаах хугацаанд эрэлттэй мэргэжил эзэмшүүлж, халагдсаны дараа ажлын байраар хангах замаар орон нутгийн ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх, Монгол Улсын мэргэжилтэй хүний нөөцийг бүрдүүлэх зэрэгт чухал ач холбогдолтой болсон билээ.

Мөн Засгийн газрын 2025 оны ээлжит хуралдаанаар Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтын журам, Олон улс судлалын төв байгуулах тухай, Орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургууль зохион байгуулах тухай, Батлан хамгаалахын материаллаг нөөцөөс шатахуун, тосолгооны материал түр гаргах журам, 2026 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай зэрэг 30 гаруй асуудлыг танилцуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулан ажиллалаа.

Батлан хамгаалах сайдын зөвлөлийн хуралдааныг 2025 онд төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологи, инновац туршилт, үйлдвэрлэлийн нэгдсэн төв байгуулах тухай, Батлан хамгаалах яамнаас баримтлах Эрдэмтэн бэлтгэх бодлогын баримт бичгийг шинэчлэх тухай, Зэвсэгт хүчний нэгтгэл анги, байгууллага, хууль эрх зүйн хүрээнд өөрийн үйл ажиллагаанаас нэмэлт орлого олох боломжийн санал тооцооны талаар, Энхийг дэмжих ажиллагааны шинэчилсэн журмуудын тухай, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн талаар авах арга хэмжээний тухай зэрэг 20 гаруй асуудлуудыг хэлэлцэн холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллалаа.

Батлан хамгаалах үйл ажиллагааг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахад жинтэй хувь нэмэр оруулсан 20 дугаар зууны түүхэн үйл явдлын нэг болох 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойг Засгийн газрын 2025 оны 189 дүгээр тогтоолын дагуу ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Тус ойн арга хэмжээний хүрээнд 2025 онд нийт 36 ажил арга хэмжээ улс орон даяар төлөвлөн амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд эх орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөө, чөлөөний үнэ цэнийг ухамсарлан ойлгуулах, дайнд оролцсон ахмад дайчдын алдар гавьяаг сурталчлан таниулж түгээн дэлгэрүүлэх, үндэсний эв нэгдэл, дайчин уламжлалаар бахархах эх оронч үзлийг залуу хойч үеийнхэнд төлөвшүүлэх чухал үйл явдал болсон билээ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний командлагчийн санаачилгаар зохион байгуулсан ахлах офицерын жилийн хүрээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд хамтран 2025 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд үр дүнд суурилсан 26 ажил арга хэмжээг төлөвлөн улс орон даяар амжилттай хэрэгжүүллээ. Сөрөн тэсвэрлэх чадавх, батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 16 төрийн захиргааны төв байгууллага болон 21 аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийг хангах зорилгоор яамдын харьяа агентлаг, төрийн

байгууллагууд, сум, дүүргийн дайчилгааны даалгавар тогтоож, дайчилгааны төлөвлөгөөг 20 жилийн дараа шинэчлэн батлуулсан.

Мөн Засгийн газрын тогтоолоор Зэвсэгт хүчний 065 дугаар анги, нийслэлийн зарим дүүрэг, дүүрэгтээ дайчилгааны сургуулийг орон нутгийн хамгаалалтын сургалт дадлагатай хамтатган 3 үе шаттайгаар явуулсан болно. Энэхүү нэгдсэн сургууль нь агаарын цэргийн болон нийслэлийн дайчилгааны бэлтгэл бэлэн байдлыг хангах анги салбарын байнгын болон оногдуулсан бүртгэгдсэн цэргийн бэлтгэл үүрэгтэн бусад томилгоот бүрэлдэхүүний мэдлэг дадлага, ур чадварыг дээшлүүлсэн чухал ач холбогдолтой сургууль болсон. Түүнчлэн Дархан-Уул, Хөвсгөл, Сүхбаатар, Архангай, Завхан, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн сургалтыг зохион байгуулж үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлсэн.

Мөн оюутан цэрэг цэргийн мэргэжил олгох сургалтын журмыг шинэчлэн боловсруулж, сургалтад 63 их, дээд сургууль, коллежийн 1-3 дугаар дамжааны оюутнууд хамрагдах боломжийг бүрдүүлж, 2025 онд 97 оюутан цэргийг хамруулж 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний тоог нэмэгдүүлсэн. 2025 онд эрэлттэй мэргэжил эзэмших сургалтыг Мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж, Зэвсэгт хүчний 8 ангид 15 мэргэжлээр 370 хугацаат цэргийн албан хаагчийг суралцуулж төгсгөөд байна аа.

Мөн монгол хэл, мэдээллийн технологи, англи хэлний сургалтад Зэвсэгт хүчний 22 нэгтгэл ангийн хугацаат цэргийн албан хаагчийг 100 хувь хамруулан ажилласан байна аа. Энхийг дэмжих ажиллагаа Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний албан хаагчид 2002 оноос эхлэн НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж ирсэн бол анх удаа сургалтын хөдөлгөөнт бүлгийг Бүгд Найрамдах Киргиз Улсад илгээж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн ажиллагааны өмнөх сургалтыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэх сургалтыг амжилттай зохион байгуулж явууллаа. Тус сургалтыг явуулснаар Монгол Улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох ажиллагааны оролцоог шинэ шатад гаргах ч гадаадын гадаад улсын энхийг сахиулагчдыг сургаж бэлтгэж, монгол цэрэг дэлхийн цэрэг гэсэн хэмээх брэндийг бататгасан ажил болсон байна аа.

Мөн БНӨСудан улсад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багийн хэрэгцээт 14 нэгж техник, 4 генераторын яг ажиллагааны газар орон дээрээс худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлсэн. Зэвсэгт хүчний зэвсэг техникийн шинэчлэх, сэргээн сайжруулах төрлийн сайжруулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зэв, сумны үйлдвэрийг ашиглалтад оруулж 9 мм-ийн сум, 7.62 мм LPC сум, 7.62 мм-ийн ПС зэрэг 3 төрлийн сумыг дотооддоо үйлдвэрлэж эхлээд байна аа. Мөн зэвсэгт хүчний хэрэгцээнд нийт 1.6 тэрбум төгрөгийн 9 нэр төрлийн 94 ширхэг дрон робот нохойг худалдан авч, зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад хуваарилж үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлсэн.

2025 онд Зэвсэгт хүчний нэгтгэл анги салбаруудын авто техникийн бэлэн байдлыг дээшлүүлж 13 тэрбум төгрөгийн өртөг бүхий 117 нэгж туулах чадвар сайтай тусгай тоноглолтой авто техникээр нөхөн хангаж, техникийн бэлэн байдлыг 4.1 хувиар нэмэгдүүлсэн байна аа. Үүнээс гадна АНУ-аас 341.3 мянган ам.доллар-ын үнэ бүхий 2 нэгж трейлер, Энэтхэг улсаас Кибер аюулгүй байдлын сургалтын төвд шаардлагатай 450.2 сая төгрөгийн үнэ бүхий компьютерын сэлбэг хэрэгсэл, Канад

улсын зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх багийн цэргийн багт хандивласан 850 ширхэг хүн нэг бүрийн анхан шатны тусламжийн багцыг буцалтгүй тусламжийн хүрээнд хүлээн авахын зэрэгцээ БНХАУ-ын Батлан хамгаалах яамнаас 70 сая юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд родаликацын станц авахаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

Яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн зардлаар 6, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр 16, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19, нэмэлт санхүүжилтээр 6, ЭТТ ХК-ийн санхүүжилтээр 6, нийт 53 арга хэмжээг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан батлуулж, худалдан авах үйл ажиллагааны цахим системд хуулийн хугацаанд байршуулж, холбогдох ажил арга хэмжээг авч ажилласан байна аа.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн урсгал зардал 718.7 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал 65.8 тэрбум төгрөг нийт 784.5 тэрбум төгрөгийг батлуулан сайдын тушаалаар санхүүжилтийг олгон ажиллалаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн урсгал зардал 677.1 тэрбум төгрөгөөр, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал 62.4 тэрбум төгрөгөөр нийт 739.5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, шинжлэх ухаан, инновац, техник технологи, аж үйлдвэрийг хөгжүүлэх цэргийн албан хаагчийг сурган бэлтгэх ажлын хүрээнд батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологид шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлуулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн чуулганаар соёрхон батлуулсан. Ингэснээр цэрэг техникийн хамтын ажиллагаатай улс орны тоо нэгээр нэмэгдэж, Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжсөн байна аа.

2025 онд олон орны зэвсэгт хүчтэнтэй хамтарч хааны эрэлд 2 талын хамтарсан Сэлэнгэ, Зэв, Зам, Баланс Мэйжик, Нүүдэлчин заан, Анатоли, Шийдэмгий шийдвэр тусгай ажиллагааны сургалт, мэргэн буудагч, дроны сургалт, цэргийн багийг чадавхжуулах сургалт, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа зэрэг сургуулиудыг амжилттай зохион байгуулсан бөгөөд үүний зэрэгцээ анх удаа БНСУ-ын хуурай замын цэргийн инженерийн салбартай хамтран Гүүр 2025 сургуулийг зохион байгуулж, Зэвсэгт хүчнээс 2100 гаруй цэргийн албан хаагчийг үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлсэн. Батлан хамгаалах салбарын албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах ажлын хүрээнд албан хаагчдын орон сууц, хашаа байшин худалдаж авах урьдчилгаа төлбөрт зориулж нэг албан хаагчид 20 сая төгрөг буюу 105 албан хаагчид 2.1 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон. Мөн Монголбанктай хамтран ажиллаад 100 хүнийг ипотекийн зээлд хамруулан ажилласан байна аа.

Түүнчлэн тив дэлхийн спортын тэмцээн уралдаанд амжилт гаргасан Алдар спорт хорооны 5 тамирчин, нийгмийн хамгааллын дэмжлэг нэн шаардлагатай үндэсний батлан хамгаалах их сургуулийн 2 албан хаагчид орон сууцын батламж олгоод байна аа. 2025 онд гадаад хамтын ажиллагаатай 13 орны цэргийн академи их дээд сургууль болон мэргэшүүлэх сургалт дамжаанд нийт 471 цэргийн албан хаагч суралцаж байгаа бөгөөд өмнөх оноос гадаад улсад суралцуулах бүрэлдэхүүний тоог 28.4 хувиар нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ Цэргийн албан

хаагчдын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогчдод анх удаа цалин хөлсийг сар бүр, тээврийн зардлыг жил бүр олгож эхэлсэн нь албан хаагчдыг сургаж бэлтгэх, чадавхжуулах, нийгмийн хамгааллыг сайжруулсан чухал ажил болсон гэж үзэж байна аа.

Батлан хамгаалах материаллаг нөөцийг бүрдүүлэх, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шат дараатай арга хэмжээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сангийн сайдын 2025 оны 197 дугаар тушаалаар төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүний үр дүнд Зэвсэгт хүчний анги...

Г.Тэмүүлэн: Илтгэлийг дуустал минутыг нэмж өгье.

Д.Батлут: Зэвсэгт хүчний нэгтгэл анги салбарууд батлагдсан төсвөөс гадна Засгийн газрын шийдвэрээр эх орны бүтээн байгуулалт, газар тариалан, намрын ургац хураалт, эрчимжсэн аж ахуй зэрэг төсөл арга хэмжээнүүдээс бүрдүүлсэн нэмэлт орлогыг зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Мөн Зэвсэгт хүчний нэгтгэл анги салбаруудад туслах аж ахуйг шинэ шатанд гаргахтай холбогдуулан 2.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий газар тариалан, ХАА-н трактор тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу худалдан авч, Зэвсэгт хүчний нэгтгэл анги салбаруудад хуваарилан өгсөн. Улсын төсвийн урсгал хангалтаар 8 тэрбум төгрөгийн шатахуун тосолгооны материал, 8.6 тэрбум төгрөгөөр хүнс хуурай эдлэлийг худалдан авч, хангалтыг зохион байгуулсан бөгөөд дайчилгааны нөөц хүнс, хуурай хэрэглэлийн 70 хувь, шатахуун тослох материалыг 100 хувь сольж шинэчлээд байна аа.

2025 онд бүтээн байгуулалтын болон барилга байгууламжийн засвар үйлчилгээний ажлуудыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, 24 төсөл арга хэмжээ хэрэгжихээс Улсын комисст ажилласан 21, барилга угсралтын 4 төсөл арга хэмжээг хэрэгжиж ажиллаж байна аа.

Батлан хамгаалах яам 2025 онд Монгол Улсын Засгийн газраас баримталж буй хүний хөгжлийг дээшилсэн хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнүүдээ бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа. Анхаарлаа хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батлан хамгаалах сайдад баярлалаа. Яамны 2025 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Ганбямба, Батлан хамгаалах ерөнхий хянан шалгагч бригадын генерал Болдбаатар, тус яамны ТНБД хошууч генерал Ганхуяг, тус яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга хурандаа Гансүх, Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга хурандаа Батхуяг, Батлан хамгаалах яамны бодлогын хэрэгжилт зохицуулалтын газрын дарга байгаа тиймээ бригадын генерал Мөнхбаяр, Батлан хамгаалах яамны орон нутгийн хамгаалалт дайчилгааны газрын дарга хурандаа Энхболд гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна аа.

Батлан хамгаалахын сайдаас мэдээллийг хийлээ. Мөн горимын санал гаргасан байгаа Батлут сайдаас. Хаалттай мэдээлэл хийх хүсэлтэй байна аа гээд. За ингээд энэ асуудлыг байнгын хорооны гишүүдийн олонхоор шийдвэрлэх ийм үүрэгтэй байгаа. Тэгэхээр санал хураалт явуулж таарна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалтад бэлтгэсэн байдлыг хараадахъя. 9 гишүүн байна. Миний бие орох юм байна. Ингээд 10 боллоо. Хаалттай горимд шилжье гэсэн санал хураалтыг горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

55.6 хувиар дэмжигдлээ. Хаалттай горимын бэлтгэлийг хангая. 5 минут.

13.40 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА